

**2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИД СУРАГЧ ЭЛСҮҮЛЭХ УДИРДАМЖ**

ЗОРИЛГО: Өөрийн хүсэл мөрөөдөл, зорилгын төлөө шамдан суралцах зорилготой сурагчдад боломж олгох үүднээс ЕБШМС-ийн 10 дугаар ангийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

ЭЛСЭХ СУРАГЧДАД ТАВИХ ШААРДЛАГА, ХЯНАЛТЫН ТОО:

2021-2022 оны хичээлийн жилд ЕБС-ийн 9 дүгээр анги төгсөж, суурь боловсрол эзэмшигчдээс 20 сурагч элсүүлж, 2022-2023 оны хичээлийн жилд ЕБШМС-ийн 10 дугаар ангид суралцуулна.

ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ:

1. Элсэхийг хүсэгчдийг 2022 оны 06 сарын 06-ны өдрийн 16:00 цагаас 06 сарын 16-ны өдрийн 16:00 цагийг дуустал <http://202.21.114.244/shinemongol-10> цахим хаягаар бүртгэж, бүртгэлийн дугаар олгох ба бүртгүүлэгч нь регистрийн дугаараар цахим бүртгэлд зөвхөн нэг удаа хандах боломжтой.
2. Бүртгүүлэгчийн овог нэр, регистрийн дугаарыг кирил үсгээр алдаагүй бичнэ.
3. Бүртгүүлэгч цээж зургаа JPEG, PNG, JPG өргөтгөлөөр оруулах бөгөөд зурган файлыг өөрийн нэрээр нэрлэсэн байна.
4. Шалгалтыг сургуулийн хичээлийн байранд зохион байгуулах тул бүртгүүлэгч заавал биеэр ирж шалгалт өгнө. Шалгуулах анги танхим, суудлын дугаар нь цахим бүртгэлийн системээр очно. Бүртгэлтэй холбоотой асуудлыг бүртгүүлсэн e-mail хаягаар илгээх тул тогтмол ашигладаг e-mail хаяг, холбоо барих утасны дугаарыг заавал бичнэ.
5. Бүртгэлийн хураамж 10'000 төгрөгийг <http://202.21.114.244/shinemongol-10> хаягаар орж QPAY үйлчилгээг ашиглан QR код уншуулан төлнө. Голомт банкаар тооцоо хийх боломжгүйг анхааруулж байна.
6. Бүртгэл амжилттай болсноор бүртгүүлэгч цахим бүртгэлийн системд нэвтрэх эрхтэй болох бөгөөд 06 сарын 19-ний өдөр бүртгэлийн системд шалгалт өгөх анги, суудлын дугаар тавигдсан байна.

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН АГУУЛГА, ХЭЛБЭР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

1. Элсэлтийн шалгалтыг танхимаар зохион байгуулна.
2. Шалгалт нь БШУЯ-наас баталсан суурь боловсролын цөм хөтөлбөрийн үндсэн агуулгын хүрээнд байна.
3. Тестийн шалгалтыг 150 минутын хугацаанд дараах 5 хичээлийн нэгдмэл агуулгаар авч, оноожуулна. Үүнд:
 - a. Математик 40 оноо
 - b. Монгол хэл 15 оноо
 - c. Англи хэл 15 оноо
 - d. Хими 15 оноо
 - e. Физик 15 оноо
4. Шалгуулагч нь шалгалт эхлэхээс 10 минутын өмнө шалгалт өгөх ангидаа ирсэн байна.
5. Сурагчдыг тестийн шалгалтын оноогоор жагсааж, эхний 20 сурагчийг ярилцлагад хамруулна.

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ХУГАЦАА:

1. Тестийн шалгалтыг 2022 оны 06 сарын 20-нд 11:00-13:30 цагийн хооронд зохион байгуулна. Шалгалтад ирэхдээ бүртгэлийн системээс бүртгэлийн хуудсаа хэвлэж авчирна.

2. Тестийн шалгалтын оноогоор эхний 20-д жагссан сурагчидтай 2022 оны 06 сарын 21-нд ярилцлага хийнэ. Ярилцлагын хуваарийг цахим бүртгэлийн системд байршуулна. Ярилцлагад эцэг, эхийн хамт оролцоно.

ДҮН МЭДЭЭ:

1. Тестийн шалгалтын дүнг 2022 оны 06 сарын 20-ны 17:00 цагт багтаан бүртгэлийн дугаараар нь "Шинэ Монгол сургууль" фэйсбүүк хуудас болон бүртгүүлсэн e-mail хаягаар, цахим бүртгэлийн системээр мэдээлнэ.
2. Тестийн шалгалт болон ярилцлагад тэнцсэн сурагчид эцэг эхийн хамт 2021 оны 06 сарын 21-ний өдөр элсэн суралцах батламжийг сургуулийн захирлаас гардан авна. Батламж олгох хуваарийг цахим бүртгэлийн системд байршуулна.

ХОЛБОО БАРИХ: Сургуулийн утас 7777-5599
Ахлах сургуулийн сургалтын менежер 95124216
Цахим бүртгэлтэй холбоотой асуулт 99012097
Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, гомдол
school@shinemongol.edu.mn хаягаар тус тус хүлээж авна.

СУРГУУЛИЙН ЗАХИРГАА